

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2020 ОНД БАЙГУУЛСАН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


2021.01.04

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн шууд захирагчийн 2020 онд байгуулсан Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журам”-ын 4.7-д заасны дагуу Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэг дэх хэсэгт бодлогын баримт бичигт тусгагдсан 5 зорилт 8 арга хэмжээний 1 нь үнэлэх боломжгүй, биелэлтийн дундаж **96** хувьтай, хоёр дахь хэсэгт төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 6 зорилт 7 арга хэмжээний 1 нь үнэлэх боломжгүй биелэлтийн дундаж **85** хувьтай, гурав дахь хэсэгт хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилт 5 арга хэмжээний 1 нь үнэлэх боломжгүй биелэлтийн дундаж **77** хувьтай байна. гурав дахь хэсэгт хуулиар олгосон нийтлэг үүрэгт 7 зорилт 11 арга хэмжээний 1 нь үнэлэх боломжгүй ба биелэлтийн дундаж **91,5** хувьтай байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 16 арга хэмжээ, хэрэгжих шатандаа байгаа арга хэмжээ 11, үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2020 онд нийт 23 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ туссанаас жилийн эцсийн хэрэгжилт **87,3 хувьтай** буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэж байна.

Жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан гүйцэтгэх ажлын хүрээнд дүгнэсэн. Өөрөөр хэлбэр 2020 оны төлөвлөсөн ажлын хэрэгжилт биелсэн бол 100 хувьтай байхаар дүгнэсэн. Ковид 19 цар тахлын хорио цээрийн дэглэм, төсөв багасгах шалтгаантай холбоотой хийж гүйцэтгээгүй арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж дүгнэсэн ба үнэлгээний нийт дүнд оруулж тооцоогүй болно.



Үүнийг 1 дүгээр графикаар хувилж үзүүлэв

ХОЁР: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ ҮНДЭСЛЭН ЦААШИД АНХААРЧ АЖИЛЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1.1.1 Биеийн тамир, спортын чиглэлээр иргэн, аж ахуй нэгж, байгууллагтай хамтран ажиллах, нийтийг хамарсан арга хэмжээг мэдээлэл түгээхэд чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг тодорхой болгож тайлагнах; ажлын хэрэгжилт 2,3 хувьтай байгааг анхаарах;

1.4.2.2 Үндэсний шигшээ багийн тамирчдын цар тахлын улмаас тогтоосон хорио цээртэй холбоотойгоор бэлтгэл цугаларалтад тамирчидад хэрхэн яаж бэлтгэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж байгааг тодорхой болгож тайлагнах;

3.1.1 Биеийн тамирын ажил үйлчилгээг төр болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах 1.1.1 зорилтын хэрэгжилт дээр дахин тайлагнасан. Цаашид арга хэмжээний нэр, үйл ажиллагааг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой заах;

3.1.2 Монголын оюутны спортын V наадмын бэлтгэл ажил хангагдаж тэмцээний үйл ажиллагаа эхэлсэн боловч цар тахал дэгдсэн тул үйл ажиллагааг зогсоосон тул санхүүжилтийг буцаан татах,

3.2.7 Архивын нэгж бүрдүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, баримтын бүрэлдэхүүн, өөрчлөлт хөдөлгөөний талаарх тоо бүртгэл, мэдээ хэрхэн хангагдаж байгааг тоо, баримтаар тайлагнах;

3.2.9 Байгууллагын төсөв, хүний нөөц, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг ил тод байх, шалгуур үзүүлэлт тодорхойгүй түүнд хүрч ажилласан хувь, тайлан мэдээг цаашид дэлгэрэнгүй тайлагнах. /Тайланг сайжруулах/;

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД

Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай танилцаж үнэлж дүгнэхэд дараах хүндрэлүүд гарлаа. Үүнд:

1. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4.4-т заасны дагуу Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж дээр хэрэгжилтийн тайланг нэгтгэхдээ газар, хэлтэс мэдээллийн бүрэн байдал, боловсруулалтыг нягтлан эцэслэх ажил бүрэн хийгдэж хэвшээгүй байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах шаардлагын дагуу гүйцэтгэлийн тайлангийн иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл, үнэмшил төрүүлэхүйц, тодорхой, товч байх, 2000 тэмдэгтэд багтаах, үр дүнд хүрсэн эсэх, хүрээгүй тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах байдал газар, хэлтсүүдэд хангалтгүй байна.

3. Тухайн гүйцэтгэлийн тайлан, батлагдсан төлөвлөгөө дахь арга хэмжээний суурь болон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, мөнгөн дүнг өөрчилсөн, түүнийг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт нь оновчгүй, үндэслэлгүй байдал цөөнгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээсэн чиг үүргийн хүрээнд бүрэн, зөв төлөвлөх тал дээр хангалтгүй байна,

2. Тайланг бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, тодорхой байдлаар тайлагнах байдал хангалтгүй хэвээр байсаар байна,

3. Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврыг хангаагүйн зэрэгцээ баталсан төлөвлөгөө дахь суурь болон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, оновчгүй зэрэг зөрчил байна.

4. “Ковид-19” цар тахлын улмаас тогтоосон хорио цээр бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан олон нийтийг хамарсан сургалтын арга хэмжээ, гадаад дотоодын сургалт хийх боломжгүй болсон ч зарим ажлуудыг хугацаа алдалгүй цахимаар хийх шаардлагатай гэж үзэж байна.

5. Өөрөөр хэлбэл зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтдээ хүрээгүй, төсөв хөрөнгө, цаг хугацааг үр дүнтэй зарцуулж чадаагүй тул “үр дүнгүй” үнэлэх боломгүй гэж үзэж 0 хувиар үнэлэв.

6.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын чиг үүргийн хүрээнд бүрэн, чанарын шалгуурыг оновчтой, бодитоор тодорхойлж боловсруулж байхад анхаарч ажиллах шаардлагатай: Үүнд:

1.Бодлогын баримт бичгүүдийн тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажил

2.Өмнөх оны төлөвлөгөөнөөс биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ

3.Тайлан боловсруулах ажлыг ажилтнуудын чиг үүрэгт нарийвчлан тусгаж, тайланг товч, тодорхой, хүрэх түвшин, түүнийг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн тайлагнах чадварыг сайжруулах,

4.Үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах тал дээр арга хэмжээ авч сайжруулах,

5.Төлөвлөгөөнд туссан ажил, түүний хүрэх түвшинтэй уялдуулан газар, хэлтсүүд төлөвлөгөөг нягтлан үзэж төлөвлөх шаардлагатай байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН: ДАРГА
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: А/МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТСҮХ

О.БОЛОРМАА